



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 5/29

Хэрлэн сум

Түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэнхэрмандал сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Цэцэгмаа нь өндөр насны тэтгэвэр авах эрх үүсч, ажлаас чөлөөлөгдсөн тул 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн тус сургуулийн багш Д.Отгондуламыг сургуулийн захирал томилогдох хүртэл түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

Хоёр. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /С.Мөнхцэцэг/-д даалгасугай.

Гурав. Сургуулийн захирлын түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Д.Отгондуламын цалинг ТҮБД-н 7-ын 1 дүгээр шатлал /673849/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг сургуулийн нягтлан бодогч /Л.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс / Г.Лхагвахатан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА